МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр Дугаар А/07 Мөрөн сум

Тээвэрлэлтийн үйл ажиллагааг
түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэд байгууллагаас ирсэн санал хүсэлт болон ажлын хэсгийн танилцуулгад "Могойн гол" ХК-иас хүнд даацын тээврийн хэрэгсэл Цэцэрлэг-Мөрөн-Эрдэнэтийн чиглэлд олон удаагийн давтамжтай нүүрс тээвэрлэлт хийсний улмаас олон салаа зам гарч тоосжилт үүсч, байгаль орчинд сөргөөр нөлөөлж, Бүрэнтогтох, Цагаан-Уул сумдын ард иргэдийн амар тайван байдлыг алдагдуулж, зам дагуу хог хаягдал нэмэгдэж, улсын чанартай авто замд эвдрэх бодитой нөхцөл байдал үүсэж байгаа тул 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зохицуулалт хийх хүртэл хугацаанд "Могойн гол" ХК-иас Цэцэрлэг-Мөрөн-Эрдэнэтийн чиглэлд нүүрс тээвэрлэхийг түр зогсоосугай.

2. Дээрх хугацаанд аймгийн дотоодын хэрэгцээнд шаардлагатай нүүрсийг худалдан борлуулахдаа MNS4598:2020 стандартад заасан жин тонныг баримтлан ачилт хийхийг "Могойн гол" ХК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Ууганбаярт, дотоодын хэрэгцээний нүүрс тээвэрлэлтэд стандартад заасан жин тонныг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Т.Ганхуяг), Авто тээврийн төв (Ө.Баттулга) нарт тус тус даалгасугай.

3. Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогсоосон хугацаанд Эрдэнэт чиглэлд нүүрсний ачилт хийхгүй байхыг "Могойн гол" ХК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Ууганбаярт, нүүрсний тээвэрлэлт хийхгүй байхыг нүүрс худалдан авах гэрээ байгуулсан аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4. Тухайн үйл ажиллагаанд удирдамж боловсруулан байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Т.Ганхуяг), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Авто тээврийн төв (Ө.Баттулга) нарт тус тус даалгасугай.

5. Орон нутагт дотоодод нүүрс худалдан авах гэрээ байгуулсан аж ахуй нэгж байгууллагын гэрээний дүн нь өөрийн бодит хэрэгцээтэй нь нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт явуулж илэрсэн зөрчлийг арилгахыг аймгийн мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Т.Ганхуяг) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Үүссэн нөхцөл байдлыг арилгах, холбогдох стандартыг мөрдөж нэг дор олон машин цувж явахгүй байхаар тооцож байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй нүүрс тээвэрлэх шийдэл, санал боловсруулж танилцуулахыг "Могойн гол" ХК-ийн захирал О.Ууганбаяр Авто тээврийн төв (Ө.Баттулга) нарт тус тус даалгасугай.

7. Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг хориглосон хугацаанд тухайн үйл ажиллагаатай холбоотой өдөр бүр аймгийн Засаг даргыг мэдээллээр хангаж ажиллахыг "Могойн гол" ХК-ийн захирал О.Ууганбаяр, Авто тээврийн төв (Ө.Баттулга) нарт тус тус үүрэг болгосугай.

8. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Х.Ган-Очир)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

5. Орон нутагт дотоодод нүүрс худалдан авах гэрээ байгуулсан аж ахуй нэгж байгууллагын гэрээний дүн нь өөрийн бодит хэрэгцээтэй нь нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт явуулж илэрсэн зөрчлийг арилгахыг аймгийн мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Т.Ганхуяг) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Үүссэн нөхцөл байдлыг арилгах, холбогдох стандартыг мөрдөж нэг дор олон машин цувж явахгүй байхаар тооцож байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй нүүрс тээвэрлэх шийдэл, санал боловсруулж танилцуулахыг "Могойн гол" ХК-ийн захирал О.Ууганбаяр Авто тээврийн төв (Ө.Баттулга) нарт тус тус даалгасугай.

7. Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг хориглосон хугацаанд тухайн үйл ажиллагаатай холбоотой өдөр бүр аймгийн Засаг даргыг мэдээллээр хангаж ажиллахыг "Могойн гол" ХК-ийн захирал О.Ууганбаяр, Авто тээврийн төв (Ө.Баттулга) нарт тус тус үүрэг болгосугай.

8. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Х.Ган-Очир)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН